



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/370

Ховд

Хөрөнгө олж бэлтгэх
зөвшөөрөл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.5, 41.2.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, компьютер, авто машин худалдан авахад зориулан орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалттай Булган сумын эмнэлгийн барилга угсралтын ажлын 2018 оны үлдэгдэл санхүүжилтаас техник хяналтын зардал 25123595 төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг зарцуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/-д зөвшөөрсүгэй.

2. Тус газрын Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан 2018 оны 2018/29 дугаартай гэрээний дагуу техник хяналтын зардлын 30 хувьтай тэнцэх 25803487 төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийн зарцуулах эрхийг нэмж нийт 50927082 төгрөг /тавин сая есөн зуун хорин долоон мянга наян хоёр/ -ийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн сангийн нэмэлт дансанд шилжүүлж гүйлгээ хийхийг Санхүү, төрийн сангийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

3. Хөрөнгө худалдаж авах нээлттэй тендер зохион байгуулж, хөрөнгийг нягтлан бодох хуулийн дагуу данс бүртгэлд тусгаж орлого болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/370 Ch
02 01849